

МОНГОЛЫН ХӨГЖИЛ БА ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГ ДЭХҮҮН


Д. Дотно, МІСС-ГИЙН СУДАЛГААНЫ ШИНЖЭЭЧ

2011-10-17

Хөгжлийг яаж хэмжих вэ? Хамгийн түгээмэл эдийн засгийн хэмжүүр болох Дотоодын Нийт Бүтээгдэхүүний өсөлтийг дэлхийн хэвлэл мэдээллийнхэн заримдаа хөгжилийн хэмжүүр болгож ярьдаг. Монголын ДНБ ойрын жилүүдэд 10-аас дээш хувь хүрнэ гэж маш их шуугиан дэгдэж, гадаадын хөрөнгө оруулагч нар Монгол руу тэмүүлнэ. Зарим нэг нь Монголчуудын амьдралын түвшин дээшилсэн гэж ч бас ярьдаг. Харамсалтай нь ДНБ нь жинхэнэдээ ард түмний амьдрал ба амьжиргааны түвшинийг бараг хэмждэггүй юм. Харин ч хөгжлийг хэмжих бусад хэмжүүрийг авч үзэхэд Монгол улсын маань хөгжил хурдсаж байгаа нь харагдахгүй байгаагийн хажууд зарим нэгэн үзүүлэлт доройтож байна.

ДНБ гэж юу вэ? ДНБ-г тооцоолоход ердөө л нийт хувийн хэрэглээний зардал, төр засаг болон аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалтын хэмжээ ба экспорт импорт хоёрын ялгааг нийлүүлж дүгнэдэг. ДНБ-ий нэг чухал дутагдал нь аливаа улсад болж байгаа бизнес, гүйлгээг л хэмжиж байгаа болохоос биш эдгээр гүйлгээнээс хэн эцэстээ орлого олж байгааг үзүүлдэггүй. Орлогыг гадаадын хүмүүс, аж ахуйн нэгжүүд олж байсан ч ДНБ-д тооцдог. Энэ асуудлыг анзаарсан эдийн засагчид Үндэсний Нийт Орлого

ДНБ ба Үндэсний Нийт Орлого (2010 оны төгрөг)




гэгч хэмжүүрийг зохиожээ. ҮНО нь аливаа улсын ард түмэн, аж ахуйн нэгжүүд ба засгийн газрын орлогыг тооцоолдог учраас улсаа хэр баяжиж байгааг хэмжихэд ҮНО-г авч үзсэн нь илүү тохиромжтой байдаг.

Ер нь ДНБ ҮНО-оос ихэнхидээ ялимгүй өндөр байдаг ч энэ

хоёр үзүүлэлт нилээд ойрхон гардаг билээ. Гэтэл Монголын сүүлийн хэдэн жилийн үзүүлэлтийг авч үзвэл бас нэг сонин зүйл харагдах юм. 90-ээд оноос хойш нилээд ойрхон явж байсан энэ хоёр үзүүлэлт нь сүүлийн 5-жилээс эхэлж том ялгаатай болж байгаа нь тодорхой. Монголчуудын орлого нь ДНБ-гээ дагаж адил хурдтай өсөхгүй байгаагаас гадна 2009-10 оны хооронд ДНБ эрс өссөн байхад ҮНО буурсан байна.

Ер нь хөгжлийг зөвхөн мөнгөөр тодорхойлох ёсгүй учраас Нобелийн шагналтай хөгжлийн эдийн засагч Амартя Сен ба Махбуб үл-Хак зэрэг эдийн засагчид хүний амьжиргааны түвшин, эрүүл мэнд, соёл боловсрол, эрх-зүйн байдал зэрэг зүйлсээр ДНБ-ийг орлуулахыг санал болгохын тулд Хүний Хөгжилийн Индексийг (ХХИ) зохиосон юм. Энэ индекс нь


Хүний Хөгжлийн Индекс (ХХИ)



дундаж наслалтын индекс, боловсролын индекс ба нэг хүнд ногдох ДНБ-ийн индексийг дундажлаж үздэг. Харин Монголын ХХИ-ийн өсөлт сүүлийн 10 жилд илүү хурдтай өссөн шинж алга байна. Харин ч 2000 оноос хойш нэмэгдэж байсан хурд нь бараг хэвээр байна.

Эдгээр ерөнхий индексүүд нь дундаж наслалт гэх мэт хэдхэн жилийн дотор өөрчлөгддөггүй зүйлсийг авч үздэг учраас нөгөө ДНБ-ээр хэмжигдээд байгаа хурдтай хөгжлийг дагаж чадахгүй байж магадгүй. Тийм учраас Монголчуудад шууд мэдрэгддэг, бас хөгжилийг шууд ба шууд бусаар хэмждэг зарим


Халдварт Өвчин Туссан Хүний Тоо



хүн амын 10%-иас хэтэрсэн 10 хүрэхгүй улсуудын нэг нь Монгол юм (бусад нь Африкийн дайны хөлд нэрвэгдсэн орнууд ба Боливи). Харин Сүрье, цусан суулга зэрэг өвчнүүд эрүүл мэндийн салбар хөгжөөгүй газруудад түгээмэл үүсдгийг бодвол сүүлийн 10 жилд Монголын хүн амын эрүүл мэндийн байдал дээрдээгүй бололтой.

Өрхийн амьжиргааны түвшинийг оновчтой тодорхойлдог нэг хэмжүүр нь хоол хүнсэнд зориулсан зардалын хувь хэмжээ юм. Хүн ер нь орлого ихтэй болох тусам нийт зардлынх нь харьцангуй цөөхөн хувь нь хоол хүнсэнд хүрэлцэж “амь зуухын төлөө” ажиллах шаардлагагүй болдог. Харин сүүлийн 10 жилд Монголчууд хүнсэнд хэдэн хувийн зардлаа зориулсныг харвал 2006 оноос хойш амьдрал улам хүндэрсэн гэж харагдаж байна.

Бүртгэгдсэн Ажилгүйдэл




Монголчуудад ямар нэгэн сайн эсвэл муу мэдээг дуулгаж байгаа биш гэдгийг бид ойлгож, бусад шалгуураар улсынхаа хөгжилийг хэмжих хэрэгтэй. Зах зээлийн тоглоомд хүн болгон өөрийн эрх ашгийг боддог учраас ДНБ магадгүй хөрөнгө оруулагч нарт чухал үзүүлэлт байж болно. Гэхдээ Монгол Улсын хувьд бол ДНБ-ээс өөр үзүүлэлтүүдийг чухалчилж хэлэлцэх нь хөгжлийг хэмжихэд илүү ач холбогдолтой юм.

Тоо баримтыг Монгол Улсын Үндэсний Статистикийн Хороо болон Нэгдсэн Үндэсний Байгууллагын мэдээллийн сангаас ашиглав.

нэгэн үзүүлэлтийг авч хэлэлцье. Халдварт өвчин, өрхийн нийт зардлын хүнсэнд зарцуулагдах хувь хэмжээ, ажилгүйдэл зэргийг авч үзэж хүмүүсийн амьдралын түвшинийн өөрчлөлтийг ойлгож болох юм.

Сүүлийн 10 жилд халдварт өвчин туссан хүний тоо маш тогтворгүй байв. Вируст Хепатитийн тоонд амьдрлын бохир орчиноос үүсдэг шар өвчнөөс авхуулаад зөвхөн цусаар дамжин халдварладаг элэгний С-вирус хүртэл багтдаг. Харин дэлхийд С-вирустай хүний тоо нь нийт

Өрхийн Зарлагаас Хүнсний Бүтээгдэхүүний Эзлэх Хувь



*Тоо баримтын эргэлзээний улмаас 2010 оны тоог IV-XII сарын дундаар тооцов

Ажилгүйдэл ч бас сүүлийн хэдэн жилд ихсэж байгаа нь илэрхий. Зурган дээрхи бүртгэгдсэн ажилгүйдэл нь жинхэнэ ажилгүйдлээс бараг 3 дахин бага гардаг байж болзошгүйг 2008-2010 оны хооронд Үндэсний Статистикийн Хорооноос хийсэн Ажиллах Хүчний Судалгааны дүн үзүүллээ. Тэгээд ч 2011 оны 8-р сар гэхэд бүртгэгдсэн ажилгүй иргэдийн тоо 2010 оныхоос их болсон байна.

Ер нь Монголын ДНБ-ийн өсөлт нь ихэнхи Монголчуудад ямар нэгэн сайн эсвэл муу мэдээг дуулгаж байгаа биш гэдгийг бид ойлгож, бусад шалгуураар улсынхаа хөгжилийг хэмжих хэрэгтэй. Зах зээлийн тоглоомд хүн болгон өөрийн эрх ашгийг боддог учраас ДНБ магадгүй хөрөнгө оруулагч нарт чухал үзүүлэлт байж болно. Гэхдээ Монгол Улсын хувьд бол ДНБ-ээс өөр үзүүлэлтүүдийг чухалчилж хэлэлцэх нь хөгжлийг хэмжихэд илүү ач холбогдолтой юм.